



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

2017 оны 3 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 51

Улаанбаатар
хот

Үндэсний хороог шинэчлэн байгуулах тухай

1. Агаарын тухай хуулийн 6.2, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2017 оны 03-03 дугаар зөвлөмжийг үндэслэн “Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо”-г “Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо” бөлгөн шинэчлэн зохион байгуулж, бүрэлдэхүүнийг 1 дүгээр, Үндэсний хорооны ажиллах журмыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Энэ захирамж гарсантай холбогдуулан “Үндэсний хорооны бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн батлах тухай” Ерөнхий сайдын 2016 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 120 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Ж.ЭРДЭНЭБАТ

Байгаль орчин, аялал
жүүлчлалын сайд

Д.ОЮУНХОРОЛ

ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ
ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга -Монгол Улсын Ерөнхий сайд
- Дэд дарга -Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
- Гишүүд:
-Улсын Их Хурлын Агаарын бохирдлыг бууруулах
асуудлын дэд хорооны дарга (зөвшилцсөнөөр);
-Монгол Улсын Ерөнхийлөгчийн Амьдрах орчин, ногоон
хөгжлийн бодлогын зөвлөх (зөвшилцсөнөөр);
-Нийслэлийн Засаг дарга;
-Батлан хамгаалахын дэд сайд;
-Гадаад харилцааны дэд сайд;
-Сангийн дэд сайд;
-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд;
-Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд;
-Барилга, хот байгуулалтын дэд сайд;
-Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын дэд сайд;
-Зам, тээврийн хөгжлийн дэд сайд;
-Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд;
-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд;
-Эрүүл мэндийн дэд сайд;
-Эрчим хүчний дэд сайд;
-Онцгой байдлын өрөнхий газрын дарга;
-Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын
дарга;